



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1/137

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 16.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг нэгдүгээр, “Шингэрүүлсэн шатдаг хийн тоног төхөөрөмжийн техник ашиглалтын галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхдээ хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа ашиглан ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын эрх бүхий албан тушаалтан нарт даалгасугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргин
2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн
тушаалтын нэгдүгээр хавсралт



**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭХ АВТО
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналт шалгалт хийх байгууллага	
Шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн нэр	
Регистрийн дугаар	
Тээврийн хэрэгслийн зориулалт	
Дарга, захирал (иргэн, эрхлэгч)-ын нэр, холбоо барих утасны дугаар:	
Тээврийн хэрэгслийн улсын дугаар, үйлдвэрлэгдсэн улс, он, марк загвар, арлын дугаар_жин	
Хяналт шалгалтын төрөл	
Хяналт шалгалт хийсэн огноо	

2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГЛЭЛ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан эсэх		Тайлбар	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Хангасан	Хангаагүй		
1	2	3	4	5	6	
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх.				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангасан эсэх.				
3	Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж	Аюултай ачаа тээвэрлэх автоцистерн, чиргүүлийн торхыг тээвэрлүүлэгч нь шахсан хийн баллоныг тухайн аймаг, нийслэлийн стандартчилал хэмжил зүйн газар, хэлтсээр баталгаажуулсан.				

	болжошгүй ачаа тээвэрлэх журмын 3.4					
4	Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болжошгүй ачаа тээвэрлэх журмын 3.5	Онцгой байдлын газар, хэлтсээр аюултай ачааг ачиж, буулгах, тээвэрлэх ўил ажиллагаатай холбоотой гарч болжошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан эсэх.				
5	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 8.2	Аюултай ачаа тээвэрлэх жолооч нь дор дурдсан шаардлагуудыг хангана.				
6		Тухайн ангилалд тохирсон жолоодох эрхийн үнэмлэхтэй, мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй. (тухайн тээврийн хэрэгслийг 3-ч доошигүй жил жолоодож дадлагажсан)				
7		Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, галын аюулгүй байдлын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх.				
8		Аюултай ачааны чиглэлээр зохих сургалтад хамрагдсан.				
9	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 6.5	Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хагас жил тутамд (жилд 2 удаа) хамрагдаж тэнцсэн байх.				
10	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 6.3, 6.4	Үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, хийц, хэмжээг өөрчилсөн авто тээврийн хэрэгслийг аюултай ачааны тээвэрлэлтэд ашиглахыг хориглоно.				
11		Байршил тогтоох төхөөрөмж (GPS), эсхүл тахографоор тоноглогдсон байх бөгөөд тэдгээр нь хяналт тавих эрх бүхий байгууллагын сүлжээнд холбогдсон, бүрэн ажиллагаатай, мэдээлэл дамжуулах боломжтой.				
12	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 6.12, 6.13	Тээврийн хэрэгслийн урд болон ард “Аюултай ачаа” таних тэмдгийг байрлуулсан.				
13		Аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь “Хурдны дээд хязгаар” зөвшөөрсөн хурдны дээд хэмжээг хараар бичсэн таних тэмдгийг тээврийн хэрэгслийн зүүн ард тавьсан.				
14	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 6.6, 6.7, 6.8	Тэсэрч дэлбэрэх, хялбар авалцан асах шингэн, хийн ачааг тээвэрлэх авто тээврийн хэрэгслийн утааны яндан нь ачаа хэт халах, гол авалцах аюулгүй, ачааны хэсэг болон шатахууны савнаас хол байрласан хийцтэй.				
15		Шатахууны савыг урд болон хойд талаас нь төмөр хаалтаар, доод талаас нь 10x10 мм нүх бүхий төмөр тороор хамгаалсан, хамгаалалт				

		болон түлшний савны хооронд 20 мм-ээс багагүй зйтай байхаас гадна шатахуун гоожих тохиолдолд шууд газарт асгарах боломжтой.			
16		Авто тээврийн хэрэгслийн яндан нь оч хамгаалагчаар тоноглогдсон.			
17		Цахилгаан хэлхээ гал хамгаалагчаар хамгаалагдсан.			
18		Цахилгаан хэлхээг шууд салгах унтраалгыг жолоочийн бүхээгт гарын дор байрлуулсан.			
19	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 6.9	Амархан авалцах шингэн, хийн төлөвт байгаа ачааг тээвэрлэх Автоцистерн нь металл гинжин газардуулагч болон цахилгаан цэнэг саармагжуулах бусад тоноглолтой байна.			
20	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 6.12, 6.14.4	Авто тээврийн хэрэгслийн бүхээг галд тэсвэртэй, бат бөх материалыар хийгдсэн, бэхэлгээ сайтай байхаас гадна жолоочийн бүхээгээс 150 мм-ээс багагүй зайд тусгаарлагдсан, агааржуулалт хийх бололцоогоор хангагдсан, хаалга нь нэмэгдэл цоожоор тоноглогдсон.			
21		Амархан гал авалцах, цацраг идэвхт, хорт хийн болон хүчтэй ўйлчилгээтэй хортой, халдварт өвчний нян бүхий ачааг тээвэрлэх авто тээврийн хэрэгсэлд "Орохыг хориглоно" тэмдэг 2-ыг авч явна			
22	Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмын 2.8	Автоцистерний ба чиргуулийн торхны баруун, зүүн гадна талд "Галын аюултай" гэсэн бичилтийг хурц ялгарах өнгөөр заавал бичсэн байна.			
23	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 19.3, MNS5566:2020 стандарт 11	Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийг стандартад заасны дагуу (5-20кг) 2 ширхэг гал унтраагуур байрлуулсан эсэх.			
24	Аюултай ачаа.	Аюултай ачаа тээвэрлэх авто тээврийн хэрэгсэлд заавал авч явна.			
25	Ангилал	Шингээг дэр			
26	тээвэрлэлтэд	Хог хаягдлыг цуглуулах сав			
27	тавих ерөнхий	Ослын зогсолтын тэмдэг			
28	шаардлага	Нүүр хамгаалах баг			
29	MNS4978:2025	Анхааруулах хантааз			
30	стандартын 7, 2-р хүснэгт	Зөөврийн гэрэлтүүлэх хэрэгсэл /оч үүсээдээгүй байх/			
31	Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж	Хамгаалах бээлий, нүд хамгаалах хэрэгсэл			

	болжошгүй ачаа тээвэрлэх журмын 3.5, 3.6					
Чиргүүл						
32	Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS4978:2025 стандартын 6.3, 6.9	Үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, хийц, хэмжээг өөрчилсөн авто тээврийн хэрэгслийг аюултай ачааны тээвэрлэлтэд ашиглахыг хориглоно.				
33		Чиргүүл нь металл гинжин газардуулагч болон цахилгаан цэнэг саармагжуулах бусад тоноглолтой байна.				
34		Чиргүүлийн металл хийцлэлд, тоноглолд шүүрэлт өгсөн эсэх.				

Хяналт шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт
Гүйцэтгэлийн шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт

3.БАТАЛГААЖУУЛАЛТ:


Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг	Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг	Хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг
/ албан тушаал /	/ албан тушаал /	/ албан тушаал /
/ овог, нэр /	/ овог, нэр /	/ овог, нэр /
/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /

Тайлбар:.....

.....

.....

Онцгой байдлын өрөнхий газрын даргын
2025 оны... дүгээр сарын...-ны өдрийн
тушаалын хоёрдугаар хавсралт



**ШИНГЭРҮҮЛСЭН ШАТДАГ ХИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ТЕХНИК АШИГЛАЛТЫН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналт шалгалт хийх байгууллага	
Шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн нэр	
Регистрийн дугаар	
Объектын нэр, хаяг, солбицол	
Байгуулагдсан огноо	
Үйл ажиллагааны чиглэл, давхрын тоо	
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/- ын нэр, холбоо барих утасны дугаар:	
Удирдамжийн дугаар	
Хяналт шалгалтын төрөл	
Хяналт шалгалт хийсэн огноо	

2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГЛЭЛ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан эсэх		Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Хангасан	Хангаагүй	
1	2	3	4	5	
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж сууринуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримталсан эсэх (төвөгшлийн ангиллаас хамаарна)			
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх			

3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангасан байдал			
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.3	Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэл хөтөлсөн эсэх			
5	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.20	Хийгээр ажилладаг ахуйн хэрэгсэл (хийн зуух, ус халаагч, хий түгээгч), хийн баллоныг галын аюулгүйн дүрмийн дагуу барилгын гадна талд барилга, зоорини болон хагас зоорини давхрын орцноос 5 метрээс дотогш зайд байрлуулан хийн баллоныг шатахгүй материалыаар хийгдсэн тусгай саванд (баллоны дээд хэсэг, редукторыг хаасан шүүгээ, гэртэй) хийж, барилгын битүү хана бүхий талд байрлуулна.			
6	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.21	Хийн баллон хадгалах тусгай сав нь цоожтой, агаар сэлгэлтийн хавхалгатай байх бөгөөд “Галын аюултай. Шатдаг хий” гэсэн анхааруулах тэмдэгтэй байрлуулсан байна.			
7	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.24	Хийн тулгыг 2.2 метрээс дээш өндөр таазтай, агаар сорох суваг болон салхи оруулах цонхтой галлагаа хэрэглэдэггүй байранд барилгын халаах хэрэгслээс 1 метр, цахилгаан халаагчаас 3 метр зйтай байрлуулна.			
8	Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрмийн 2.1 дэх заалт	Хийн тоног төхөөрөмжийг угсралтыг хийн аж ахуйн байгууллагын боловсруулж баталсан зургаар гүйцэтгэсэн.			
9	Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрмийн 3.11.1 дэх заалт	Хий алдагдал илрүүлэх, дохиолох багаж хэрэгсэлтэй. Тэдгээр нь хэвийн ажиллагаатай.			
10	Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрмийн 4.7 дэх заалт	Шаталтын бүтээгдэхүүнийг зайлзуулах утааны яндантай.			

11	Хийн хангамж БНБД 42-01-04 5.2.	Хий зохицуулгын цэгийн байршил БНБД-н шаардлага хангаж байгаа эсэх			
12	Хийн хангамж БНБД 5.12.	Хий зохицуулгын төхөөрөмжийг механик гэмтлээс хамгаалах хамгаалалттай байрлуулах ба байрлуулсан өрөө нь гэрэлтүүлэгтэй байвал зохино.			
13	Хийн хангамж БНБД 42-01-04 5.12.	Хий зохицуулгын төхөөрөмжийг А, Б ба В зэрэглэлийн өрөөнд, шатны доорх хөндийд байрлуулахыг хориглоно.			
14	Хийн хангамж БНБД 42-01-04 5.14.	Хий зохицуулгын цэг болон хий зохицуулгын төхөөрөмжид шүүлтүүр, хамгаалалтын хаагч хавхлаг, хийн даралтыг тохируулагч, хамгаалалтын гаргалтын хавхлаг, хаалтын арматур, хяналт хэмжилтийн хэрэгслүүд, хийн даралт зөвшөөрөгдсөн хэмжээнээс багасах буюу ихсэхэд дуут дохио өгдөг дохиоллын хэрэгсэл суурилуулах зайлшгүй шаардлагатай.			
15	Хийн хангамж БНБД 42-01-04 6.29.	Орон сууцны барилгад хийн зуухыг 2,2 м-ээс доошгүй өндөртэй, байгалийн гэрэлтүүлэг бүхий агааржуулалтын сорох хоолойтой, цонх нь салхивчтай гал тогооны өрөөнд байрлуулах хэрэгтэй.			
16	Хийн хангамж БНБД 42-01-04 6.33.	Хийн зуух байрлуулах хэсгийн шавардлагагүй хана болон бусад шатах материалыар хийсэн ханыг үл шатах материалыар тусгаарлаж, тусгаарлагч нь зуухны хэмжээнээс хааш хаашаа 10 см-ээс багагүй, дээшээ 80 см-ээс багагүй хэмжээтэй байна.			
17		Өрөөний тусгаарлагч бүхий хана, хийн зуух хоёрын хооронд 7 см-ээс багагүй, эсрэг хана хүртэл 1 м-ээс багагүй зйтай.			
18	Хийн хангамж БНБД 42-01-04 6.50. 9.52	Олон хүн цугларах барилгын зоорь, техникийн өрөө, нийтийн хоолны газрын хооллох болон худалдааны танхим, байгалийн гэрэлтүүлэггүй өрөөнд хийн төхөөрөмж, баллон суурилуулах, байрлуулахыг хориглоно.			
19	Хийн хангамж БНБД 6.51.	Хийн төхөөрөмж байрлуулах өрөө нь байгалийн гэрэл сайн ордог, тогтмол ажиллаж байдаг өгөлт-соролтын агаар сэлгэлтийн систем байх			

		хэрэгтэй. Агаар сэлгэлт нь ажлын цагт З дахинаас, ажлын бус цагт нэг дахинаас доошгүй давтамжтай байвал зохино.			
20	Хийн хангамж БНБД 9.49	Ганцаарчилсан баллонт төхөөрөмжийг орон сууцны 2-оос дээш давхар бүхий барилга дотор байрлуулахыг хориглоно.			
21	MNS5566:2020 стандарт 8.1	Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийг стандартад зааснаар байрлуулсан эсэх			
22	MNS5566:2020 стандарт 8.7	Гал унтраагуурын савны дээд хэсэг нь шалны түвшингээс дээш 1,35м хүртэлх өндөрт байхаар тооцон хананд бэхэлж хүмүүсийн хөдөлгөөнд саад болохгүй, авч хэрэглэхэд хялбар, нарны шууд тусгал тусахааргүй газар байрлуулсан эсэх			
23	MNS5566:2020 стандарт 8.12	Байгууллага, аж ахуйн нэгж бүр гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт, бэлэн байдал хариуцсан албан тушаалтныг томилж анхан шатны багаж хэрэгсэл нэг бүрийг хяналтын карттай болгож хагас жилд нэг удаа үзлэг хийж чанар байдлын талаар тэмдэглэгээ хийсэн эсэх			
24	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143:2013 5.5.1, 5.5.2-т заасны дагуу гэрэлтэгч заах тэмдэг байрлуулсан эсэх.				

Хяналт шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт
Гүйцэтгэлийн шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт

3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг	Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг	Хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг
/ албан тушаал /	/ албан тушаал /	/ албан тушаал /
/ овог, нэр /	/ овог, нэр /	/ овог, нэр /
/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /